

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж

2016.02.05.

2016 он гарсаар улсын хэмжээнд давхардсан тоогоор 12 аймгийн 24 суманд галзуу, цэцэг, шүлхий, цусан халдварт, хорт салст халуурал зэрэг 5 төрлийн өвчин гарч 953 толгой мал өвчилнөөс 808 толгой малыг устгаж, булшлан, ариутгал халдваргүйтгэл хийж, хорио цээрийн дэглэм тогтоож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Иймд цагаан сар болох гэж байгаатай холбогдуулан мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд дараахи зөвлөмжийг өгч байна.

1. Малд өвчний шинж тэмдэг илэрвэл өөрийн харъяалах мал эмнэлгийн байгууллага болон малын эмчид яаралтай мэдэгдэх, дуудлага өгөх,
2. Малаа хоньчлон хариулах, өвчний сэжиг илэрсэн айлын малтай нийлүүлэхгүй байх,
3. Малын өвчний шинж тэмдэг илэрсэн айл өрх отор нүүдэл хийх, мал худалдан борлуулах, шилжилт хөдөлгөөн хийхгүй байх,
4. Нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх /хурдан морины уралдаан гэх мэт/,
5. Үхэж хорогдсон малын хүүр сэг зэмийг булж устгах,
6. Өвчний сэжиг илэрсэн хот айлаас мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн гаргахгүй байх
7. Малын тоног хэрэгсэл / зэл, ногт, чөдөр, тохом, гэх мэт/, хашаа хороо, пүнз, өтөг бууц зэргийг халдваргүйтгэл хийх зэрэг арга хэмжээг авахыг зөвлөж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХЯНАЛТЫН ГАЗАР